

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/52/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
<b>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....</b>	<b>16</b>
<b>3.8 Аудитын гол асуудал .....</b>	<b>16</b>
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Төлбөрийн акт .....	18
Байхгүй .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Албан шаардлага .....	18
4.4 Зөвлөмж .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>51,787,078.50</b>	<b>54,977,221.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	221,805.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	221,805.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	221,805.00
31211	Төрийн сангийн харилцах	-	221,067.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	738.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	208,000.00	208,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	208,000.00	208,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	208,000.00	208,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	51,579,078.50	54,547,416.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,082,074.79	5,532,690.00
35130	Эм боох материал	5,082,074.79	5,532,690.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	46,493,503.71	49,011,226.71
35410	Бичиг хэргийн материал	1,200,273.00	847,059.00
35420	Аж ахуйн материал	33,431,825.00	32,691,775.00
35430	Сэлбэг хэрэгсэл	150,100.00	605,037.00
35440	Түлш, шатах тослох материал	6,894,431.50	3,357,271.50
35460	Хүнсний материал	4,806,874.21	11,500,084.21
35470	Бусад хангамжийн материал	10,000.00	10,000.00
35600	Мал амьтад	3,500.00	3,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>807,518,734.75</b>	<b>828,010,221.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	807,518,734.75	828,010,221.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	786,708,734.75	807,200,221.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	731,569,699.25	731,569,699.25

39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,250,417.80)	(74,646,963.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	201,560,294.00	182,810,294.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(113,845,299.41)	(154,694,464.97)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,905,632.08	178,931,263.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,310,508.01)	(66,182,041.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,038,880.00	20,488,880.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,730,329.56)	(15,847,229.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,770,784.20	4,770,784.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	20,810,000.00	20,810,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,810,000.00	20,810,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>859,305,813.25</u></b>	<b><u>882,987,443.70</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>44,175,557.00</u></b>	<b><u>44,524,197.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	44,175,557.00	44,524,197.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	44,175,557.00	44,524,197.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,965,604.00	30,836,803.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	7,209,953.00	13,687,394.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,651,917.00	13,559,394.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,558,036.00	128,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>815,130,256.25</u></b>	<b><u>838,463,246.70</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	815,130,256.25	838,463,246.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	616,072,505.76	616,072,505.76
51103	- хувьцаат	616,072,505.76	616,072,505.76
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(194,111,648.21)	(170,778,657.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	(194,111,648.21)	(194,111,648.21)
51220	Тайлант үеийн үр дүн	-	23,332,990.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	393,169,398.70	393,169,398.70

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>859,305,813.25</b>	<b>882,987,443.70</b>
---	--	-----------------------	-----------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		Төгрөгөөр	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>688,763,086.00</b>	<b>1,030,762,710.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,045,000.00</b>	<b>33,702,240.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,045,000.00	33,702,240.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,045,000.00	33,702,240.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,045,000.00	33,702,240.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>686,718,086.00</b>	<b>997,060,470.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	587,997,494.00	725,717,782.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	46,939,994.00	112,028,382.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,057,500.00	613,689,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,308,392.00	214,793,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,308,392.00	214,793,688.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	18,488,500.00	17,706,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,488,500.00	17,706,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	32,923,700.00	38,842,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,923,700.00	38,842,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>697,687,784.35</b>	<b>1,006,074,386.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>697,687,784.35</b>	<b>1,006,074,386.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	697,687,784.35	961,273,586.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	415,020,456.00	553,326,914.00
210101	Үндсэн цалин	414,971,736.00	553,326,914.00
210102	Нэмэгдэл	48,720.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,645,327.00	73,009,012.00
210201	Тэтгэврийн даатгал	34,754,427.00	42,564,253.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,989,108.00	730,089.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,972,723.00	11,922,741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	983,615.00	1,168,143.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,945,454.00	16,623,786.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,520,853.00	20,726,320.00
210301	Гэрэл, цахилгаан	1,749,353.00	1,814,400.00
210302	Түлш, халаалт	17,771,500.00	18,911,920.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,814,160.00	85,722,350.00
210401	Бичиг хэрэг	4,222,850.00	4,379,700.00
210402	Тээвэр, шатахуун	48,599,870.00	64,477,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,262,700.00	1,028,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	723,240.00	739,663.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,005,500.00	15,097,687.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	69,287,634.00	123,473,145.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,313,131.00	107,433,855.79
210502	Хоол, хүнс	10,949,765.00	16,039,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,738.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,178,450.00	7,429,483.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,303,000.00	7,429,483.00
210604	Урсгал засвар	1,875,450.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,184,300.00	3,471,400.00
210702	Дотоод албан томилолт	2,184,300.00	3,471,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,158,998.00	921,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,593,698.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	303,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	35,600.00	118,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,900.00	104,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	41,300.00	66,000.00
210807	Газрын төлбөр	54,000.00	252,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	73,500.00	76,800.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	63,877,606.35	93,193,561.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	884,600.00	1,262,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,993,006.35	91,931,561.52
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		- 44,800,800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		- 44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		- 32,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		- 12,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		- 800.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		- 800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(8,924,698.35)</b>	<b>24,688,323.69</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,355,333.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,355,333.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(1,355,333.24)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(8,924,698.35)</b>	<b>23,332,990.45</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	616,072,505.76	393,169,398.70		1,009,241,904.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>616,072,505.76</b>	<b>393,169,398.70</b>	<b>0.00</b>	1,009,241,904.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			18,076,759.35	18,076,759.35
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>616,072,505.76</b>	<b>393,169,398.70</b>	<b>18,076,759.35</b>	815,130,256.25
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>616,072,505.76</b>	<b>393,169,398.70</b>	<b>18,076,759.35</b>	815,130,256.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>616,072,505.76</b>	<b>393,169,398.70</b>	<b>-194,111,648.21</b>	815,130,256.25

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			23,332,990.45	23,332,990.45
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>616,072,505.76</b>	<b>393,169,398.70</b>	<b>-170,778,657.76</b>	<b>838,463,246.70</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>639,778,092.00</b>	<b>885,032,088.00</b>	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>639,778,092.00</b>	<b>885,032,088.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>			
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,057,500.00	613,689,400.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>			
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,308,392.00	214,793,688.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>			
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,488,500.00	17,706,600.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>			
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,923,700.00	38,842,400.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>637,558,292.00</b>	<b>883,060,283.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>637,558,292.00</b>	<b>883,060,283.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>628,406,231.00</b>	<b>838,259,483.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>			
210101	Үндсэн цалин	426,502,616.00	538,608,611.00	
210102	Нэмэгдэл	288,404,107.00	339,434,967.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	109,017,546.00	108,217,344.00	
				8,064,000.00

210104	Урамшуулал	29,080,963.00	40,861,700.00
210105	Гэрээт ажлын хөлс		42,030,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,612,800.00	93,964,060.00
210201	Тэтгэврийн даатгал	25,764,800.00	75,127,460.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,712,000.00	4,709,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,169,600.00	3,767,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	542,400.00	941,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,424,000.00	9,418,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,921,500.00	19,287,800.00
210301	Гэрэл, цахилгаан	2,174,400.00	2,804,400.00
210302	Түлш, халаалт	14,747,100.00	16,483,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53,459,100.00	68,957,712.00
210401	Бичиг хэрэг	1,838,500.00	3,149,329.00
210402	Тээвэр, шатахуун	48,180,200.00	51,960,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,427,000.00	2,003,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,013,400.00	1,559,999.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,285,033.30
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	70,009,415.00	104,903,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,239,309.00	78,533,700.00
210502	Хоол, хүнс	10,176,000.00	22,409,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,594,106.00	3,960,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,110,000.00	4,572,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,543,000.00	3,540,000.00
210604	Урсгал засвар	1,567,000.00	1,032,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,184,300.00	3,471,400.00
210702	Дотоод албан томилолт	2,184,300.00	3,471,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,774,000.00	1,089,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,208,700.00	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	35,600.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,900.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,000.00	70,600.00
210807	Газрын төлбөр	54,000.00	252,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	76,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,832,500.00</b>	<b>3,405,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,832,500.00	3,405,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,152,061.00</b>	<b>44,800,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		32,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		12,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,152,061.00</b>	<b>800.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,152,061.00	800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,219,800.00</u></b>	<b><u>1,971,805.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,219,800.00</b>	<b>1,750,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,219,800.00</b>	<b>1,750,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,219,800.00</b>	<b>1,750,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,219,800.00	1,750,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(2,219,800.00)</u></b>	<b><u>(1,750,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	221,805.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		221,805.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>214,792,150.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>214,792,150.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	169,992,150.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	67,691,111.00
210101	Үндсэн цалин	67,691,111.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,390,260.00
210201	Тэтгэврийн даатгал	30,390,260.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,613,200.00
210301	Гэрэл, цахилгаан	630,000.00
210302	Түлш, халаалт	1,983,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,599,779.00
210401	Бичиг хэрэг	1,103,329.00
210402	Тээвэр, шатахуун	9,768,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,153,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,029,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,580,000.00
210502	Хоол, хүнс	9,449,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	668,400.00
210702	Дотоод албан томилолт	668,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	44,800,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	44,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	214,792,888.00

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	214,792,888.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	214,792,888.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	738.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Булган сумын Эрүүл мэндийн төв нь сумын игэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Тус байгууллага нь тайлант онд “Сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, ард иргэдэд үйлчлэх” эрхэм зорилгын дор дараах зорилтуудыг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

-Эмч мэргэжилтэний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, үзлэг шинжилгээний дүгнэлтийн чанар, хууль шинжлэх ухааны үндэслэлийг ахиулахад онцгой анхаарах

- Байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээг өргөнөөр ашиглах, хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд төлөвлөгөөт шалгалт хийсэн байна.

Эрүүл мэндийн төв нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Тус Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 706.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.7 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	221.8	221.8
Авлага	208.0	208.0	-
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	51,579.1	54,547.4	2,968.3
Үндсэн хөрөнгө	807,518.7	828,010.2	20,491.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>859,305.8</b>	<b>882,987.4</b>	<b>23,681.6</b>

Өр төлбөр	44,175.6	44,524.2	348.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	815,130.3	838,463.2	23,332.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>859,305.8</u></b>	<b><u>882,987.4</u></b>	<b><u>23,681.6</u></b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд томилолтын зардлаас хэмнэсэнтэй холбоотой үлдэгдэлтэй гарсан байна.

Авлага дансанд урьд онуудаас шилжиж ирсэн эзэн холбогдогчгүй 0.2 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54.5 сая төгрөг болж 2.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 33.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хандиваар, 201.9 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч үйл ажиллагаандаа 232.6 сая төгрөгийн бараа материал зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 828.0 сая төгрөг болж 20.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.8 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 112.0 сая буюу нийт 113.8 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ИТХ ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 133 тоот огтоолоор 38.1 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж акталж, үндсэн хөрөнгөнд 91.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлд 17.4 сая, цалингийн ашигт 19.6 сая, эмийн 7.1 сая, хүнсний материалын 0.1 сая, нийт 44.2 сая төгрөгийн өр төлбөртэй байсан байна. . Оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 11.2 сая, цалингийн ашигт 19.6 сая, эмийн зардалд 7.2 сая, хоолны зардалд 0.1 сая, тээвэр шатахууны 6.0, бусад зардалд 0.4 сая төгрөгийн өртэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,381.6 сая төгрөг болж 27.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 27.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,030.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 342.0 сая төгрөгөөр буюу 49.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй орлого болон хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 308.4 сая төгрөгөөр буюу 44.2 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал болон бусад урсгал шилжүүлэг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант онд хөрөнгө акталсантай холбоотой, дахин үнэлгээний зөрүүгээр 2.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга гарсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 670.2 сая төгрөг ба тодотгол хийгдээгүй байна. Үүнээс тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 613.7 сая, орон нутгийн

төсвөөс санхүүжих 17.7 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого 38.8 сая төгрөгөөр батлагджээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 670.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 613.7 сая, орон нутгийн төсвөөс санхүүжих 17.7 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 38.8 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 670.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд томилолтын зардлыг 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт төсвийн 70.2 хувийг цалин, 9.5 хувийг НДШ-ийн зардал, 2.5 хувийг тогтмол зардал, 7.7 хувийг хангамж бараа материалын зардал, 8.3 хувийг норматив зардал, 1.8 хувийг бусад зардал эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 214.8 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн харилцах дансар хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 67.7 сая, нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 30.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.6 сая, хангамж, бараа материалын зардалд 16.6 сая, нормативт зардалд 50.0 сая, томилолт, зочны зардалд 0.7 сая, бусад урсгал шилжүүлэгт 44.8 сая, нийт 214.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 738 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 84 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй, 33 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн дүнтэй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн 3 дугаар улирлын мэдээг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл 26.9 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 858.7 сая төгрөгийн 25 гүйлгээг оруулаагүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг дутуу оруулсан, 42.2 сая төгрөгийн өр үүсгэсэн тухай 5 шийдвэрийг байршуулаагүй, өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж 43.8 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр шилэнд дансанд оруулбал зохих 116 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд зөвлөмж өгсөн ба Эрүүл мэндийн төвийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 52 дугаартай албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна. Тайлант оны байдлаар хэрэгжилтийг шалгаж үзэхэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын дүнгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, давтан гаргасан тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 998.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 942.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 54.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1.Нэр бүхий ажилтанд 0.3 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон боловч суутгаж аваагүй, тайланд авлагаар бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 14.4.2 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 0.3 сая төгрөгийн цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 934.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож оруулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл 26.9 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 838.7 сая төгрөгийн 25 гүйлгээг оруулаагүй, 26.9 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээ, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг дутуу оруулсан, 42.2 сая төгрөгийн өр үүсгэсэн тухай 5 шийдвэрийг байршуулаагүй, өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж 43.8 хувь байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 6.4.8 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөв.

2. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нь 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр орлогод авсан 8.2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийг эмийн захиалга бичиж, хяналтгүйгээр анхан шатны бүрдэл дутуу баримтаар шууд зарцуулалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 14 дүгээр зүйлийн 14.3.2, 14.3.3, 14.3.4 дэхь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар хяналтгүй зарцуулалт хийхгүй байх, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар албан шаардлага өгөв.

3. Булган сумын Эрүүл мэндийн төвийн дотор эмийн сан болон Эргэлтийн эмийн санг нэг хүн хариуцаж ажилладаг, эмийн ширхэгийн тооцоо хийдэггүй, эргэлтийн эмийн сангийн бараа материалын тайланг хөтлөөгүй, сангийн бүртгэл тооцоо хангалтгүй хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-ийн 5.1.1, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалтууд, 13 дугаар зүйлийн 13.6, 14 дүгээр зүйлийн 14.3.2, 14.3.3, 14.3.4 дэхь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмийн тайлангийн бүртгэл тооцоог сайжруулах, Эргэлтийн эмийн санг тусгаарлаж, бүртгэл тооцоонд нь тавих хяналтын сайжруулах талаар албан шаардлага өгөв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Гэрэл цахилгаан, хангамж бараа материал, хоол, хүнс, багаж, техник хэрэгсэл, томиллолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэгээс нийтдээ 54.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй бүртгэж тайлагнасан байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэхь заалтуудыг мөрдөж, гүйлгээг тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын ЭМТ	4	998.1			1	0.3	2	942.9	1	54.9